



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

Завхан аймаг

ЗӨСТ нь байгалийн голомтот болон зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тандан судлах, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлэх, зоонозын хүний өвчлөлийн, тохиолдол дэгдэлтийн үеийн эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг.

Түүхэн замнал

Алсын хараа
Эрхэм зорилго

Бүтэц, зохион
байгуулалт

Хамт олон

Үйл ажиллагаа

ХАЯГ:

Завхан аймаг, Улиастай
сум, Жинст баг

Утас: 70462432

www.facebook.com/zavkhangots

Цахим шуудан:

zavkhangots@yahoo.com

Түүхэн замнал

Зоонозын өвчин судлалын төв нь 1937 оны 06-р сарын 15-нд Завхан аймгийн Улиастай хотод “Тарваган тахал эсэргүүцэх отряд” нэртэйгээр манай улсын хөдөө орон нутагт байгуулагдсан анхны мэргэжлийн байгууллага юм.

Тарваган тахал эсэргүүцэх отрядын даргаар ЗХУ-ын их эмч А.К.Борзенков гэдэг хүн ажиллаж байжээ. Тус байгууллага Сайд нарын зөвлөлийн 1961 оны 510-р тогтоолоор Гоц аюулт халдварт өвчнийг эсэргүүцэн судлах аймаг дундын станц болон өргөжиж Увс, Ховд, Завхан аймгуудыг харъяалан ажиллаж иржээ.

Эрүүл мэндийн сайдын 2007 оны 339 тоот тушаалаар Байгалийн голомтот халдварт өвчин судлалын төв болж үйл ажиллагаагаа явуулж байгаад ЭМС-ын 2012 оны 271-н тоот тушаалаар Зоонозын өвчин судлалын төв болон өөрчлөгдөж эмнэлгийн орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр хангагдан лабораторийн оношлогооны чадавхийг бэхжүүлж, хүн амыг байгалийн голомтот болон шинэ ба сэргэн тархаж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, өвчлөл гарсан тохиолдолд оношлох, өвчний голомтыг цомотгон дарах, мэрэгч амьтдын дундах эпизоотыг тандан судлах, хайж илрүүлэх голомтын идэвхжилтийг тогтоох зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын хөдөлмөрийн алдартануудаас дурьдвал:

“Сүхбаатар”-ын одон:

- Шархүүгийн Очир лаборант 1976 онд

“Хөдөлмөрийн гавъяаны улаан туг” одон:

- Тогтохын Цангарав санитор 1961 онд
- Бадарчийн Лхагва лаборант 1981 онд
- Буджавын Энэбиш их эмч 2009 онд

“Алтан гадас” одон:

- Жадамбын Дамдинсүрэн сувилагч 1951 онд
- Шархүүгийн Очир 1971 онд
- Буджавын Энэбиш их эмч 1995 онд

“Хөдөлмөрийн хүндэт” медаль:

- С.Галсанжамц

Эрүүлийг хамгаалахын “Тэргүүний ажилтан” цол тэмдэг:

- Тус байгууллагын 12 эмч мэргэжилтэн, ажилтан нар шагнагдсан байна.

Үе үеийн удирдлагууд

- Батын Зундуй 1948-1950 он
- Дорлигийн Лхамсүрэн 1951-1952 он
- Жадамбын Дамдинсүрэн 1953-1960 он
- Чимэдийн Зундуй 1961-1962 он
- Гомбосүрэнгийн Хоролсүрэн 1963-1965 он
- Бадарчийн Нанзад 1965-1970 он
- Нүрэгийн Шура 1971-1976 он

- Чимэдийн Бямбахүү 1977 -2000 он
- Буджавын Энэбиш 2000-2011 он
- Намжилдоржийн Цэрэндорж 2011-2012 он
- Ганболдын Дашдаваа 2012 оноос одоог хүртэл ажиллаж байна.


Алсын хараа

Байгалийн голомтот халдварт өвчний эрсдлийг бууруулах, мэдлэг чадварт суурилсан төрийн үйлчилгээний манлайлагч байгууллага байна.

Эрхэм зорилго

Байгалийн голомтот халдварт өвчнөөс хүн амыг урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх, лабораторит суурилсан тандалт судалгааг эрчимжүүлэх, халдвар эсэргүүцэх оновчтой зөв бодлого, зохицуулалтаар хангах нь Зоонозын өвчин судлалын төвийн эрхэм зорилго мөн.

Байгууллагын бүтэц зохион байгуулалт



Дээд мэргэжилтэн 6, тусгай дунд мэргэжилтэн 5, бусад 6 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулан ажиллаж байна.

Манай хамт олон



Завхан аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн хамт олон

Үйл ажиллагааны зураг







